

С.НАДМИД

Нийтийн аяс
буюу
Ногоохон навчны
үлгэр



Самбуугийн Падма



Нийтийн аяс буюу

Жоогоон Навчны Цогц



УЛААНБААТАР 2007

С.Надмид

**НИЙТИЙН АЯС БУЮУ ПОГООХОН НАВЧНЫ
ҮЛГЭР**

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Зураач С.Мөнхтогтох
Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Т.Далгэрмаа



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

ИШ ҮНДЭС ХОЁРЫН ҮЛГЭР

Хөрсөнд дэвтсэн үрийн хөврөлөөс дөрвөн цагаан соёо цухуйв. Тэд цухуймагцаа доошоо зэрэг махийн газрын гүн тийш тэмүүлэв. Үүнийг хүмүүс “Үндэс” гэдэг ажээ.

Удалгүй мөнөөхөн хөврөлөөс бас нэг соёо цухуйв. Арай хожуу гарч ирсэн энэ соёо харин дээшээ матийн газар дээр гарч ирэх гэж тэмүүлэв. Үүнийг хүмүүс “Иш” гэдэг ажээ.

Иш өөрийн мэдэлгүй ийнхүү дээшээ, улам дээшээ тэмүүлэн байхдаа:

-Бид нэгэн үрээс соёолсон билээ. Гэтэл та дөрөв юунд доошоо явна вэ? Намайг яагаад ганцааранг минь газрын гадаргад гаргах гэж байна хэмээн асууж гэнэ.

Үндэс:

-Бүгдээрээ дээш зүтгэвээс хэн чамайг тэжээхсэн билээ. Үндэсгүй бол бултаараа үхэж дуусах биш үү? Ишхэн минь, ганцхан чинийхээ төлөө бид дөрөв газрын гүн рүү харван орж, их дэлхийн шимийг ирээдүйн нахианд чинь илгээж, навч, цэцэг, үр жимсийг тань тэтгэе! Амьдрал ерөөс ийм жамтай юм. Гайхах хэрэггүй гэжээ.



НАР НАХИА ХОЁРЫН ҮЛГЭР



Хөврөлийнишнээсдэлгэрсэнбяцханногоон
Нахиа хав харанхуй хар хөрсийг түлхэн,
түлхсээр газрын гадарга дээр алгуурхан цухуйсаар
гарч ирэв. Түүний цочиж гайхсан гэдэг жигтэйхэн. Нахиа:

-Пээ, энэ чинь юу гээч вэ? Би хаашаа гараад ирэв... Нүд
сохлом яасан хурц гэрэл вэ? Хатаж шатам юутай халуун юм
бэ! Би хаана хүрээд ирэв? хэмээн учиргүй сандарч гэнэ.

Нахианы энэ үгийг нар сонсоод:

-Ээ, чааваасаа. Уг нь ингэтлээ айх, мэгдэх хэрэггүй
юмсан даа. Чи одоо амьдрал гээч ер бусын гайхамшигт
сонин ертөнцийн үүдээр шагайж байна. Айх ёсгүй юмнаас
айж, гайхах хэрэггүй юманд гайхах муу гэж гэнээ.

Нарны үг үнэн байлаа. Амьдрал хийгээд
түүнийг ивээн тэтгэгч Нарны аугаа ач ивээлийг
бяцхан Нахиа аварга том мод болтлоо мөн ч
их хүртжээ.



ЭРВЭЭХЭЙ, ДЭВХРЭГ ХОЁРЫН ҮЛГЭР

Дэнгийн Эрвээхэйг айлын гэрийн хошлон дээр
зүүрмэглэн хэвтэж байтал нэгэн Дэвхрэг ирээд
мөргөчихжээ.

-Чи чинь нүдгүй лус гэгч үү? Аль эсвэл өвгөнөөрөө
тоглох дур хүрэв үү? хэмээн ихэд цочсон Эрвээхэй уурсан
өгүүлээд Дэвхрэг рүү заналтай харав. Энэ сацуу айж

балмагдсан Дэвхрэг:

-Уучлаарай! Үнэхээр эвгүй юм боллоо. Хүчээ татаж авч чадаагүйгээс таныг мөргөж орхив гэж хэлсэн авч Эрвээхэйг нэг л аргадах янзтай байхаар нь дахин ам нээж,

-Эвий, эвий. Арай бөөр, зүрх чинь бүлтэрчихээгүй биз! хэмээн хөөрхийллөө.

-Үгүй ер, хүчээ татаж авч чадсангүй гэнэ шүү. Их хүчтэй эд байх нь. Бас тэгээд эвийлээд байгаагийг нь ээ! гэж хэлээд Эрвээхэй хүйтнээр хөхөрснөө:

-Чи ер нь юу юм бэ? Ямар хачин тэнцвэргүй хөлтэй нөхөр вэ? гэж омогдов.

-Би жирийн л нэг муу шавж гэж Дэвхрэг өчөөд,

-Таныг би ер мэдэхгүй юм. Аль аймагт багтдаг амьтан бэ? гэж аядуухан асуув.

-Би юу? Би болбоос жигүүртэн. Шар шувууны төрөл! гэж Эрвээхэй ихэмсгээр хариулав.

-Пээ, ясан мундаг вэ!



-Пээ-ээ гэнэ шүү. Чи одоо болтол мэддэггүй юм уу?

-Үнэнийг хэлэхэд... Үгүй та тэгвэл яагаад биеэр хариугүй жижиг байгаа юм бэ? хэмээн Дэвхрэг сонирхон асуусанд,

-Жаахан гэнэ чи, ха-ха-ха Бас доромжлох санаатай... гэснээ Эрвээхэй бяцхан Дэвхрэгийн дээгүүр омог бардам эргэлдэн нисэв. Тэгээд,

-Миний хэр зэрэг том амьтан болохыг үзнэ үү, чи? гэж амьсгаадан асуулаа. Сониуч бяцхан Дэвхрэг,

-Үзье гэж хэлэв. Эрвээхэй,

-За, чи тэгвэл жаахан азна. Одоо энэ айл удахгүй дэнгээ асаана. Гэрэл гармагц хоёулаа орно. За юу гэж хэлэв.

Удалгүй харуй бүрий болж гэрийн тооноор гэрэл гарлаа.

-Орѐ гэж Эрвээхэй Дэвхрэгийн данхар толгой руу урт эврээрээ тоншоод шуулттай хаяа руу нисэн оров. Дэвхрэг хойноос нь хоёрхон дэвхрээд орчихлоо. Эрвээхэй:

-Чи энэ утас зүүний хайрцаг дээр суугаад миний сүүдрийг л дагуулан хараад байдаг юм шүү гэж хэлүүтээ аяганы ширээн дээр асаатай байгаа том зэс цөгцтэй дэн уруу нислээ. Эрвээхэйг дэнгийн дөлний баруун талаар ойрхон нисэж өнгөрөхөд гэрийн баруун тал сүүдэртэв. Зүүн талаар өнгөрөхөд гэрийн зүүн тал бүхлээрээ харанхуйлав. Дөлний халз дээгүүр шүргэх шахам нисэн өнгөрөхөд айлын дээвэр тооныг бүхэлд нь Эрвээхэйн сүүдэр нөмрөв.

-За ямар байна? гэж амьсгаадсан Эрвээхэй Дэвхрэгний дэргэд ирж буухдаа асуулаа.

-Ёстой бузар том амьтан юмаа! гэж Дэвхрэг сандрангуй хариулав.

-Пээ, энэ чинь юу ч биш, улам том болж чадна хэмээн хөөрөн хашхираад Эрвээхэй дэнгийн зүг ахин нислээ. Гэрэлд ойрхон өнгөрөх тутам Эрвээхэйн сүүдэр улам ч том

болох ажээ. Дэвхрэг утас зүүний том хайрцаг дээр дэвхрэх зуураа “Уваа, мөн том болов оо!” хэмээн хашхирч байлаа.

Эрвээхэй улам том сүүдэр гаргаж өөрийгөө гайхуулахын тулд дэнгийн гол руу шуудхан дайрав. Төдөлгүй “шард” хийх бяцхан дуу гараад гэрт тас харанхуй боллоо. Дахиад гэрэл асав. Гэвч Эрвээхэй буцаж ирсэнгүй. Дэвхрэг юу болсныг үзэхээр дэнгийн дэргэд дэвхрэн очвол, хөөрхий хөөрүү Эрвээхэйн бие эндсэн байжээ.

Эрвээхэй яагаад дэнд унаж үхдэгийг хүүхдүүд та нар мэдэв үү? Дэнд Эрвээхэй шатвал гэрт хаа нэгэн газар Дэвхрэг байгаа гэж бодоорой.

СОНОР СЭРЭМЖИЙН ТУХАЙ БУЮУ ЗУРАМ ЧОГЧИГО ХОЁРЫН ТУХАЙ ҮЛГЭР

Зурам бол мэргэч амьтан. Өөрөөр хэлбэл газрын амьтан. Чогчиго бол жигүүртэн. Өөрөөр хэлбэл тэнгэрийн амьтан.

Чогчиго тэнгэрээр нисэж явахдаа ертөнц дээр зурам гэж нэг амьтан байдгийг олж хараад, түүгээр тоглож болмоор санагдсан юм. Чингээд нэг өдөр Чогчиго нүхнийхээ зүг сүүлээ годойлгон үсэрч яваа Зурамны нуруун дээр дэгдэн буужээ. Зурам золтой л шургаж унасангүй.

-Та чинь одоо юун амьтан байна? Хаанаас ирээд нуруун дээр минь наалдчихав? гэж Зурамыг асуусанд Чогчиго:

-Өвгөнийгөө уучил! Намайг Огичгоч гэдэг. Чам шиг хурдан хөл, энэ шувуудын хүчирхэг жигүүрийн аль нь ч надад байхгүй. Өдөржин өнхөрч явдаг үйлтэй амьтан.



Азаар эрхмийн нуруун дээр таарч ойчлоо. Жаахан дөхүүлээч! Үнэг идэх гээд байна гэв.

-Өө, хөөрхий! Яасан ерөвдөлтэй нөхөр вэ? Хэрэв тийм бол туслалгүй яахав. Миний нуруун дээр суугаад явж байж болно. Ингэхэд чи чинь амтай юм байгаа биз дээ?

-Ам ч яахав, нэг хариугүй юм байж байна.

-Ялаа, шумуул барьж дөнгөх үү?

-Хурдан хонгор минь юу гэж?

-Миний нурууг шумуул амраадаггүй юм. Түүнээс хороож байвал чиний тус тэр

болог.

-Хичээеэ, хичээеэ.

Ингэж ярилцаад Зурам, Чогчиго хоёр "найзалж" байхаар тохиров. Чогчиго худал хэлсэн болохоор хөл далавч хоёроо зурамнаас дандаа нуудаг байлаа. Нуруун дээр нь гэнэт бууна. Бас гэнэтхэн алга болно. Тэгэхээр мэдэгдэх ч аргагүй. Хэдий тийм боловч Зурам сэжиг авчээ. Миний найзад нэг нууц явдал байна даа. Ойчив уу, гэтэл бараа сураггүй. Үнэгэнд үмхүүлчихэв үү, гэтэл дахиад л ирээд сууж байдаг. Энэ ер нь ямар учиртай найз юм бол хэмээн гайхжээ.

Нэг удаа бүүр ч илэрхий хачин юм болов. Зурмыг нүхнээсээ алсхан идшилж явтал Чогчиго нуруун дээр нь гэнэтхэн ирж суув.

-За, хурдан хонгор минь гүйгээрэй! Цаана чинь үнэг ирж явна.Амь авраарай! гэж сандаргалаа.

Зурам хоёр биеэ аврахын тулд байдаг хурдаараа жирийлээ. Чогчиго хашхичих нь:

-Гүйгээрэй, гүйгээрэй! Ай даа мөн ч хурдан байна! Гүйгээ-рэй, зүүн тийшээ, гүй-гээ-рэй, урдаас чинь! Эргээд гүйгээрэй, гүй-гээ-рэй, ха-ха-ха...


Зурам бахардан унав. Түүний хулгар чихэнд “гүйгээрэй, гүй-гээ-рэй” гэсэн доогтой дуу дуулдсаар, тэгэхдээ их л дээр агаарт сонсдож байлаа. “Энэ Огичгоч гээч арай шувуу байсан юм биш биз дээ” гэж бүүр түүрхэн санах шиг болоод зурамны ухаан балартжээ.

Үнэгний үнэрч сайран хошуу ч хөөрхий Зурамнаас гурван хуруу зайтай ойрхон байв.

ХАД МОД ХОЁРЫН ҮЛГЭР

Нэгэн нүцгэн толгойн шил дээр Хад, Мод хоёр олон жил хамт амьдарчээ. Хүүхдүүд тэднийг “Өнчин цохио”, “Өнчин хайлаас” гэж нэрлэдэг байв.Хоёр өнчин гэв гэнэт айхавтар сүрхий маргалджээ. Маргааныг мод л өджээ. Хайлаас хэлж гэнэ.

-Чамтай цуг байх яасан уйтгартай юм бэ? Чамд амь амьсгаа гэгч юм даанч алга. Ургаж төлжинө гэж үгүй. Миний л мэдэхийн нэг ийм овгор хар юм байсан. Яг тэр чигээрээ шүү



хэмээн гомдол мэдүүлжээ.

Хад чимээгүй байснаа хүнгэнэсэн тод дуугаар:

-Одоо яая гэхэв. Уйтгартай байвал явахгүй юу даа, дүү минь гэв.

-Үгүй ер дөө, хэнээс илүүдээ хөөх, туух болж байна? Бас дүү минь гэнэ шүү. Хичнээн настайдаа ингэж хэлж байна хэмээн мод агсрав.

Хад ер айсан царайгүй, аанай тайван, гайхалтай хүдэр дуугаар өгүүлэх нь:

-Чи бид хоёрын насыг эх газар маань мэднэ.

Мод улам ч уурсан навч,

мөчрөө савчин ярих нь:

-Пээ, чамд яаж эх байдаг юм бэ. Эхтэй юм бол үндэсээ үзүүл! Үрээ харуул!

Хад урьдын адил тайвнаар:

-Газар эх минь мэднэ гэж дахин хэлэв.

-Муу дүлий хар чи юу гэж зөрөх гээд байна? Ядахдаа ургамал мод шиг ургаж баймаажин их зан гаргаарай гэж Хайлаас агсран мөчирөөрөө Хадыг шавхуурдаж эхэллээ.

Модны Хаданд ийнхүү уурлах нь дэндсэн хэрэг байжээ. Юу ч атугай энэ Хад бол энэ Модноос хэдэн сая жилээр ах юм. Өчүүхэн жижиг үр салхиар хийсэн ирж дэргэдээ хэрхэн унасан, тэр үр мөчирт нь хоргодон газрын дулаан хэвлийд яаж шурган орсон, анхны нахиагаа хэзээ дэлгэсэн, хожим

сайхан мод болон ургасан түүхийг Хад нэгд нэгдгүй сайн мэддэг юм байж. Үргэлж хайрлаж явдаг юм санжээ. Хад бас оршин тогтнож байгаа газар шороогоо өөрийн эх гэж бодож, эрхэмлэн дээдэлдэг юм санжээ.

НИЙГИЙН АЯС БУЮУ БЯЦХАН НОГООН НАВЧНЫ ҮЛГЭР

Хамаг навч шарлаад байхад бил ганцаараа ногооноороо байна. Юутай ичгэвтэр юм бэ! гэж хавар орой гарсан бяцхан навч гомдол болов. Мөчир үл мэдэг чичиргэнэн:

-Удахгүй шарлах байлгүй дээ гэж тайван хариуллаа.

-Ёстой их ичиж байна. Явал нөхөд шигээ шав шар болох болоо? гэж ногоон навчийг дахин өгүүлсэнд мөчир:

-Аяндаа л шарлачихдаг юм даа гэж аанай тайван, тэгэхдээ гайхсан байдалтай санаа алдан хариулав.

Чингэтэл гэнэт
дэгдсэн хүчтэй хүйтэн
салхи аварга том
улиасны өтгөн
саглагар мөчрүүдээс
хариугүй хагдран
унах дөхсөн түмэн
түмэн навчыг
хоромхноо мөлжин



хувхайлж, агаарт хийсгээд, улмаар урт гудам уруудуулан шаржигнатал туусаар одов.

Салхи хэсэг зуур намжлаа. Үзвэл мөчирт гуравхан навч үлджээ. Мөчрөөсөө салсан мөнөөхөн навчнууд алслан одон аадрын чимээ мэт шаагин шуугисаар анир тасрахад:

-Та хоёр ичиж байна уу? Бүгдээрээ л явчихлаа шүү дээ гэж сайхь Ногоон навч зэргэлдээ байгаа хоёроосоо асуув.

-Юундаа ичих билээ. Харин ч ойчихгүй тэсээд л баймаар байна хэмээн зэрэг хариу өгүүлтэл нөгөө хоёрыг голын хүйтэн жавар мэт урт гудамж даган үерлэх жихүү хүйтэн саарал салхи эх мөчрөөс нь салгаж аваад явчихлаа. Бяцхан Ногоон навч бүх биеэрээ хүчлэн угзарч хэд сэгсрэгдсэн боловч мөчрөөсөө салсангүй. Тэр бусдаас хожуу дэлбээлсэн нахианы навч байжээ.

-Ий-ий-ий! Би л ганцаараа үлдлээ дээ! Ий-ий-ий! хэмээн үглэсээр л байв. Энэ сацуу мөчир:

-Уйлж халаглаад яахав. Унах л цагтаа унана. Амьдралын жам тийм. Хүлээж байл даа гэв. Бас дэрхийн нисэж модны оройд ирж суусан хэдэн бор болжмор:

-Ингээд өвөл болдог байжээ. Хөөрхий. Хайран сайхан мод минь нэг л өдөр нүцгэрдэг байжээ. Зайлуул хэмээн шуугилдсанаа ганцаар үлдсэн Ногоон навчийг гэнэт олж харсан бололтой,

-Хүүе, нэг байна. Хараач! Ганцхан үлдэж. Ашгүй дээ гэж шуугилдав. Мөчир:

-Сонсож байна уу., ногоохон үр минь! Нийтийн аясыг дагах зөв. Тэгэхдээ муу юманд тэгтлээ догдолж болдоггүй юм. Юундаа яарна вэ, Ногоохон үр минь! гэж хариулжээ.

МЭДЭМХИЙ БОРЫН ҮЛГЭР

Оготнууд машин зам дээрээс шуудай дүүрэн олз олов. Будаа юм болов уу, гэтэл биш. Хоёр тал нь тэгшхэн бөөрөнхий хэлбэртэй юм байлаа.

-Төмс гэдэг ч арай биш байгаа даа?

-Биш байхаа. Энэ чинь арай хөнгөхөн юм.

-Чи төмс мэддэг юм уу?

-Өнгөрсөн өвөл ой хамгаалагчийн хаяагаар орж, яг ийм шуудайтай юм байхаар нь цоолоод мэргэ үзсэн. Шороотой, нойтон гашуун эд байсан. Түүнийг лав төмс гэдэг байх.

Оготнуудыг ийнхүү ярилцаж байтал Мэдэмхий бор хүрч ирэв.

-Та нар чинь юун дээр овоороод байна аа?

-Мэдэхгүй ээ. Энд л нэг ийм шуудайтай юм байна. Юу ч гэсэн идэх юм бололтой.


Бор оготно шуудайн амаар асгарсан мөнөөхөн олзыг харуут:

-Өө, энэ чинь боорцог байна. Үүнийг чиньбоорцог гэдэг юм. Ямарамттайхан гэж сананаа! гэж хашхирав.

Оготнууд тал талаас нь:

-Боорцог гэж юу байдаг юм бэ? Хэзээ чи тийм амттанг хаанаас амталж үзээ вэ? гэж шалгаав.

-Ноднин өвөл ой хамгаалагчийн хаяагаар



орж шүүгээнд нь байсан боорцогноос иддэг байсан юм байхгүй юу. Нэг тийм боорцог идэхэд бүтэн долоо хоногийн өл даана. Тэжээлтэй, өөгийг нь яана даа.

-Тэгээд тэр чинь чухам юу юм бэ?

-Боорцог л байхгүй юу.

-Ээ, чааваас...бо-бо-орцог гэдэг чинь ургамал юм уу?

-Аль нь ч биш. Зөвхөн л хүн хийдэг байх. Үнэр нь хачин сайхан, идэхэд жигтэйхэн гоё амттай, зөөлхөн гээч!

Оготнууд энэ үгийг сонсоод мөнөөхөн олзноосоо нэг нэгийг өнхрүүлэн авч мэрэв.

-Сайхан амттай байгаа биз дээ!

-Ай мэдэхгүй. Модны хатсан холтос шиг л юм амтагдаж байна.

-Хазахад эвгүй чихар чихар гэж байна. Хатуу юм. Худлаа гэвэл чи өөрөө мэрээд үзээч.

Мэдэмхий бор мэрж үзэв. Нээрээ арай ч боорцог биш шиг. Ой хамгаалагчийнд байдаг хүүдийтэй амттаны үнэр ч алга байлаа. Гэтэл өнгө нь адилхан шаргал, хэлбэр нь гайхалтай ижилхэн бөөрөнхий ажээ. Тэгээд ч тэр үү, Мэдэмхий бор хэд тамшаалснаа:

-Боорцог л байна гэж хэлэв.

-Нээрээ юу?

-Яалаа гэж худал хэлэх вэ!

-Үнэн бол гоё доо. Ядахдаа энэ намар өвс ногоо муу ургалаа. Өвөл идэх хөөө алга. Хэрэв боорцог гэдэг үнэхээр мөн юм бол хойтон хавар болтол мэрэх хоолтой болжээ. Ээ гялай. Ээ гялай!

-Хөөө, та нар битгий шүлсээ залгиад, үхэх гээд байгаач. Одоо үүнийг идэхгүй шүү.

Борын энэ дуунаар оготнууд өмнөө байсан олзноос гурав гурван алхам ухрав.

-Боорцог мөнд л мөн. Надад итгэх хэрэгтэй. Харин эргэлзэж, хардаж байхын оронд зөөсөн нь дээр гэж Мэдэмхий бор маадгархан хэлэв.

-Яаж зөөх вэ? Үүрээд даахгүй, чирээд дийлэхгүй том юм байна.

-Нэг нэгээр нь өнхрүүлэхгүй юу.

-Яаж барах вэ, хэдэн зуун ширхэг бололтой.

Мэдэмхий бор өгүүллүүн:

-За тэгвэл энд нь орхичих. Залхуураад байвал би нүхэндээ зөөе. Дүн өвлөөр гуйгаад ирцгээв дээ гэж ихэрхэв.

Оготнууд энэ үгнээс айжээ.

-Та минь өнхрүүлцгээе. Нэг нэгээр нь өнхрүүлцгээе!

-Ура! Өнхрүүлцгээе! Амттайхан тэжээлтэйхэн хүнсээ өнхрүүлэнхэн, бөмбрүүлэнхэн зөөцгөөе! гэж шуугилдлаа.

Оготнуудын ер бусын сонин ажил нэгэнт эхэлжээ. Шуудайнаас дөрвөн зүг, найман зовхист бяцхан жим гарч, тэр нь нэг нэг нүхэнд хүрч байв..

Мэдэмхий бор шуудай дээр урд хоёр хөлөө өргөн ихэмсэг зогсоно. Тэр:

Ганцхан ширхэг нь долоон өдрийн өл даадаг

Гайхалтай сайхан боорцог доо

Өгөөмөр ачтай хэн гэгч нь энд хаяж

Өвлийн идэштэй болгов доо

Намайг таниагүй бол та нар мэдэхгүй

Намаржингаа хөөө зөөж ядарна даа.

Зөөгөөрэй, найзууд минь, зөөгөөрэй

Зөөлхөн, зөөлхөн өнхрүүлээрэй!

Илүү ч үгүй, дутуу ч үгүй нэг л оготно

Идэх боорцогноос тав, тавыг авна шүү! гэж дуулна.

Оготнууд олзоо намаржин зөөж арай чүү дуусчээ. Хөөөгөө ч базааж амжсангүй. Эцсийн “боорцогийг” өнхрүүлэн түрж оруулсны маргааш өглөө орчныг хяруу даржээ.

Тэр өвөл ер бусын их цас орж, хүйтэн болжээ. Оготнууд үүцээ задлав.

“Ганцхан ширхэг нь долоон өдрийн өл даадаг

Гайхалтай сайхан боорцог доо.

Ачтай Борын минь олж өгсөн

Амттай сайхан хоол доо” гэж дуулалдсаар хүнсээ задлав. Гэтэл хоол болсонгүй. Боорцог биш, цөм үйсэн бөглөөнүүд байсан болохоор яаж ч хоол болох билээ?

Мэдэмхий борын л гай шүү дээ.



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.